

Аман ба бичгийн зохиолоор уламжилж ирсэн ерөөлийн шинжтэй зүйлүүд

Б.Урангоо*

СУИС, Театр урлагийн сургууль, Урлаг судлал, утга зохиолын тэнхим

Хураангуй

Монгол ардын аман зохиолын дотор ард түмний ирээдүйн амьдралын аз жаргалыг ерөөсөн нэгэн хэсэг уран шүлэглэл буй. Үүнийг ерөөл гэдэг. Ерөөл нь аман зохиолын төрөл дотор бие даасан тусгай төрөл зүйл болдог учраас судалгаа шинжилгээний хийх бүрэн боломжтой сэдэв юм. Ерөөлийг дотор нь ерөөл, бэлгэ дэмбэрлийн үг гэж хоёр ангилдаг. Уг судалгааг хийхдээ дээрх ерөөл, бэлгийн үг нь монголын эртний аман зохиол болоод бичгийн уран зохиолын дурсгалуудад хэрхэн бичигдэж, хэлэгдэж үлдсэн ба тэдгээр зохиолуудад буй ерөөлийн шинжтэй зүйлүүдийг тодруулж, эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах зорилгоор уг судалгаа шинжилгээний өгүүллийг бичиж гүйцэтгэв.

XIII зууны үеийн Чингисийн төрийн дуулал болох “Эртний сайхан” монгол ардын уртын дуу, “Төрийн минь сүлд” хэмээх шүлэг зэрэг бусад төрлүүдэд ерөөлийн шинжтэй зүйлүүд байгааг нотолж, жишээ баримт зэргээр дурдаж өгөв. Мөн монгол аман зохиолын өвөрмөц төрлийн нэг болох ерөөл нь аман болоод бичгийн уран зохиолын гол дурсгалуудад хэрхэн илэрч буйг эртний уран зохиолын гол эх сурвалжууд болох “Монголын нууц товчоо”, “Хөх судар”, “Үг” зохиол, аман зохиолын дурсгал “Гэсэр”, “Жангар”-ын тууж зэргийг сонгон авч, ажиглалт хийж, жишээ баримтаар тайлбарлалаа. Монголын ард түмэн үгийн цэцнээр ярилцаж, үйлийн бэлгэдэл агуулж ирсэн угийн бэлгэ авъяастай учир тэр хэрээрээ аман зохиол нь бичгийн уран зохиолд нөлөөлж, бичгийн зохиол нь аман зохиолынхоо дурсгалыг тээж шингээж ирсэн гэдгийг эдгээр баримтуудаас үзэж болох юм. Ерөөл нь дан ганц амаар уламжлагдсангүй, бичгийн уран зохиолд монголын тухайн үеийн ард түмний аж байдал, амьдрал ахуй, ёс заншил, зан үйлийг тээж ирэхдээ соёлын олон үнэт зүйлийг агуулж иржээ.

Түлхүүр үг

Монголын нууц товчоо, Гэсэр, Жангар, Үг зохиол

Монголын эртний бичгийн уран зохиолын сонгодог эх сурвалж XIII зууны үеэс эхлэлтэй. Энэхүү бичгийн зохиолын түүхэн уламжлалын дагуу маш олон бичгийн уран зохиол бичигджээ. XIX зууны сүүл XX зууны эхээр аман зохиолын төрөл зүйлүүдийг бичгийн хэлнээ буулгаж, тэр дундаас ерөөл нь бурхны шашны нөлөөгөөр боловсрон хөгжиж, томоохон төлөөлөгчидтэй ч болсон. Ард түмний дунд өргөн хэрэглэгддэг уг ерөөл, магтаалыг бичгийн хэлэнд буулгах, зохиож найруулах, шинээр бичиж ерөөх зэрэг нь аман болон бичгийн хэлбэрт шилжсэн шинэчлэлт, өөрчлөлт, хөгжилт болж өгсөн. Судлаач Х.Сампилдэндэв “XIII зууны үед зохиогдсон “Монголын нууц товчоо”, Рашид Ад Диний “Судрын чуулган” болон европын жуулчдын тэмдэглэлийн аль алинд ерөөлтэй холбогдсон мэдээ баримт байдаггүй” (Гаадамба, Сампилдэндэв, 1988, х.116) гэж тэмдэглэжээ. Харин оросын судлаач Михайлов “Эдгээрийг зохиогчид улс төрийн шинж чанартай үйл явдалд гол анхаарал хандуулаад, цэвэр аж байдлын зураглалыг харьцангуйгаар бага бичсэн” (Михайлов, 1971, х.23) гэжээ.

Уг сэдвийг судалж байхдаа аман болоод бичгийн зохиолын дурсгалуудын дотор ерөөлийн шинжтэй зүйлүүд бий эсэхийг нягталж, ерөөлийн элементүүдийг олж тодорхойлохыг зорив. XIII зуунд ерөөлийн хэрэгцээ байсныг илтгэж, хэд хэдэн бүлэгт ерөөлтэй холбогдолтой мөртүүд ажиглагдсан. Тухайлбал: “Төрийн минь сүлд өршөө” гэж төрийн сүлд тугандаа наминчилж, мөргөдөг ёс заншил эрт үеэс тогтож үлдсэнийг бататгаж, “ТӨРИЙН МИНЬ СҮЛД” шүлэгт ерөөлийн шинж байгааг онцоллоо.

Төрийн минь сүлд
Түмэн түмэн ондоо мандаж
Төр улс минь бат
Төрсөн эх орон минь бүтэн
Түйвээх дайсан халдвал
Түймэрдэн сөнөөж
Түмэн олон маань түвшин
Түгших гамшиг зовлонгүй
Түмэн өлзийн хүсэл

Илэрхийлж сүлд тугаа өргөмүй
(Арьяасүрэн, Нямбуу, 1992, х.115-116) хэмээн Монголчууд сүлд тугандаа хандаж ёсолдог. Уг шүлэг нь Монгол улсын мандан бадралын үед байсныг илтгэнэ. Чингис хаан төрийн их

* ✉ a.gadas@yahoo.com

туг, төрийн цагаан туг, төрийн хар туг гэх мэт ялгамжилж чухал ач холбогдол өгдөг байсан нь олон эх сурвалжуудад тэмдэглэгдэн үлдсэн. Уг шүлгийг тэр үеэс эхлэн хэлж, төрийн тугандаа залбирч, мөргөдөг байжээ гэж хэлж болох юм. Ерөөлийн шинж чанартай үг хэллэг, хүсэл байгаа нь уг шүлгээс маш тодорхой харагдана. Мөн “Гэсэр”-ийн тууж нь Төвд, Монгол, Буриад, Тува зэрэг төв азийн олон ард түмний дотор өргөн дэлгэрсэн зохиол юм. Уг туульсын зохиолд ерөөл, бэлгийн үгийн шинж бага ажиглагдсан.

Ажу мэргэн Арлан гуа хатнаа аваад
Нолом талдаа буув
Чандмань эрдэнэ Цавгүй хар нүүрс
Хамаг эрдэнээр бүрдсэн
Дөрвөн өнцөгт хотын дотор
Мянган галав болтол

Суун жаргав... (Монголын уран зохиолын дээжис, 1999, х.269) гэж дайснаа дарж, энх амгалан аж төрж, жарган сууж буйг одоо цагийн бэлгэдэлт дүрслэлээр ерөөж төгсгөжээ.

Монгол ардын дуутай холбогдох нь: Тухайн үед Чингисийн төрийн дуулал гэж үздэг “Эртний сайхан” дуунд ерөөлийн зүйл байдаг. Чингисийн төрийн дуулал “Эртний сайхан” гэдэг дуу бол эрт дээр үеэс уламжлагдаж ирсэн дууны нэг юм. Энэ дууг хууччуул “Чингисийн төрийн дуулал” буюу сүлд дуулал хэмээн ихэд хүндэтгэдэг. 1930-аад оноос уг дууг дуулахаа байж, нэгэн үед бүр мартагдахад хүргэсэн. 1936 онд алдарт хуурч М.Дугаржав монгол ардын уртын дууны түүвэрт оруулж хэвлүүлсэн нь өдгөө үлдсэн. МУГЖ Ж.Дорждагва гуай 1970 онд эмхэтгэн хэвлүүлсэн “Уртын дуу” номонд оруулсан боловч уг нь ихэд өөрчлөгдсөн байсан. “Эртний сайхан” төрийн хүндэтгэлийн дуу нь ерөөлийн зохиомж, элементүүд бий бөгөөд амнаас бичгийн хэлэнд уламжлагдаж үлджээ.

“Эртний сайхан ерөөлөөр
Энэ сайхан оронд нь
Эзэн чингис хааныхаа
Язгууран ээц бүрдвээ хө
Сүмбэр уулын оройгоос
Сүндэрлэж сацраад
Сүр жавхлан дэлгэрээд
Сүлд нь бат болтугай
Хамаг номын рашааныг
Ханахуй чинээгээр хүртээд
Хаан эзэн Чингисийн өмнө

Хамаг бүгдээрээ жаргая гэх уг эхийг “Өндөр настан Вандангийн Цэвэгдоржийн “Хөдөлмөр” сонинд нийтлүүлснээс авав” (Аръяасүрэн, Нямбуу, 1992, х. 159-160) гэжээ. Үүнээс үзэхэд уг дуу нь эхлэл, өрнөл, төгсгөл гэсэн бүтэцтэй, бэлгэдэн

ерөөх шинжтэй, утга санаа нь хамаг монголоороо жарган суухыг бэлгэдэн ерөөжээ. “Эртний сайхан” уртын дууны төгсгөлийн түрлэгийн өөрчлөлт:

Хамаг эзэн Чингисийн авралаар
Хамаг Монголын эзэн бид
Хааны сүлд тугийн өмнө

Хамаг бүгдээрээ бишрэн жаргая гэж төгсдөг байсныг “Төв аймгийн Цүлтэм, мөн сумын Авиддамдинжав (1889-1950), “Шилэв” хэмээх Дондог агсан гучаад оны эхээр энэ дууг дуулдаг байсан бөгөөд М.Дугаржав агсны түүврийн дууныхтай адил байсан” (Аръяасүрэн, Нямбуу, 1992, х.159-160) гэжээ. Мөн тухайн үеийн бурхан шашны зан үйлтэй холбогдуулан оруулсан өөрчлөлт төгсгөлийн түрлэгт бий.

“Хаан эзэн Богдын өмнө

Хамаг бүгдээрээ жаргая” гэж өөрчилсөн нь бурхны шашин дэлгэрч, Богд төрийн үйл хэргийг хариуцах болсонтой холбогдуулж тухайн нийгмийн байдлыг дагаж өөрчлөгдсөн хэлбэр юм. Харин буриад ардын дунд дууны хэлбэрээр нэлээд өвөрмөц байдалтай дэлгэрчээ. Бусад газрын хувилбарт харваачдад хандан хэлсэн зүйл байдаггүй бол буриадад бий. Жишээ нь:

Хормого соохи, хотоёо
Хотойсорон татаарай
Хорин холбооной дулдаарай
Наадаг соохи хомоёо
Хубирган табяарай
Холын холбооной зондо

Сууда орон ошоорой (Балдаев, 1961, х.71) гэх мэт мэргэн цол хүртэхийг ерөөж захисан зүйл хэлдэг.

“Монголын нууц товчоо”-нд: 1976 онд хэвлүүлсэн Ц.Дамдинсүрэнгийн “Монголын нууц товчоо”, 2009 онд монголын эрдэмтдийн эмхэтгэж хэвлүүлсэн “Монголын нууц товчоо” зэрэг хоёр эх сурвалж дээр ажиглалт хийлээ. 2009 онд эрдэмтдийн эмхэтгэж хэвлүүлсэн “Монголын нууц товчоо”-ны хоёрдугаар бүлгийн 103-р зүйлд: “Мэргэдийг холдуулж, Тэмүжин Бурхан халдун дээрээс бууж, өвчүүгээ дарж өгүүлрүүн:

Хоогчин эхийг солонго болж
Сонссоны тул үнэ¹ болж, үзсэний тул
Бүтэн биеэ буруулан
Бухия² морьт болж
Бугын жим дагаж
Бургасан гэр гэрлэж
Бурхан дээр гарлаа...
Халдун бурханаа
Харцын төдий амиа
Халхлуулав, би

1 Солонгын язгуурын мэргэч амьтан

2 Уртай, чөдөртэй

Айхын ихээр айлаа, би
Бурхан халдуныг
Өглөө бүр мялаасугай!
Өдөр бүр өчсүгэй!
Ургийн ураг минь

Ухан мэдтүгэй! хэмээн наран өөд хандаж, бүсээ хүзүүндээ эрихэлж, малгайгаа гартаа сэгэлдэргэлж, гараа өвчүүндээ дарж, наран зүг есөнтөө сөгдөж, сацал сацаж, өчил өгөв” (Бира, Цэрэнсодном, Цэдэв, 2009, х.39-40) гэж ерөөлийн эхлэл, өрнөл, төгсгөл зэргийг агуулсан бүрэн ерөөлийн шинжтэй нэг зүйл бий. Эрдэмтэн Ц.Дамдинсүрэнгийн 1976 онд хэвлүүлсэн “Монголын нууц товчоо”-нд, гуравдугаар бүлэг буюу “Мэргэдийг сөнөөсөн ба Тэмүжинд Чингис хаан цол өргөмжилсөн нь” бүлэг буюу 121 зүйлд “Хорчи ирж өгүүллүүн хэсэгт “Заарин тэнгэр ирж, нүдэнд минь зааж үзүүлсэн нь, ухаагчин үнээ ирж Жамухыг тойрон явж, Жамухыг бага гэр тэргий нь мөргөсөөр өрөөсөн эврээ хугалж, солжир эвэртэй болоод “Эврийг минь өг” гэж Жамухын зүг мөөрч, шороо сацлан байна. Бас нэгэн мухар ухаа үхрийг их гэрт тэргэнд хөллөжээ. Тэр үхэр их тэргүүр (зам)-ээр Тэмүжиний хойноос зүтгэн явж мөөрөн хэлэх нь:

Тэнгэр газар эелдэж
Тэмүжинг улсын болтугай гэж

Тээж хүргэж явна гэж мөөрнө хэмээж “Миний нүдэнд заарийн тэнгэр ирж зааж үзүүлэв” (Дамдинсүрэн, 1976, хууд. 65) хэмээн ерөөдөг. Энэ нь зүүд совингийн бэлгэдлийг илэрхийлсэн ерөөлийн шинжийг агуулсан. Тэгвэл 2009 онд хэвлэгдсэн “Монголын нууц товчоо”-нд:

“Тэнгэр газар эетэлдэж

Тэмүжинийг улсын эзэн болтугай” хэмээн улс тээж авч айсуу гэж заарингууд нүдэнд үзүүлж, надад заав” (Бира, Цэрэнсодном, Цэдэв, 2009, х.53) гэж өгүүлдэг. Энэ бүлэгт ерөөлийн агуулгатай зүйлүүд олонтоо таарна. Бэлгүтэй Харалдай-Тохураун хоёрыг “Агтчин болтугай”, Тайчуудын Хуту, Моричи, Мулхалху гурвыг “Адуу адуул тугай”, Архай Хасар, Тахар, Сүхэхай, Чаурхан дөрвийг “Холыг холбогч, ойрын оторч (хол ойрыг сурвалжлах газарч) болтугай” (Дамдинсүрэн, 1976, хууд. 69) гэх мэт зарлиг боловч ерөөлийн шинж агуулсан гэж үзэж болно. 125-р зүйлд Чингис хаан, хан болж Боорчи, Зэлмэ хоёрт үгүүлрүүн:

Сүүдрээс өөр нөхөргүй байхад
Сүүдэр минь болж
Сүүлнээс өөр ташуургүй байхад
Сүүл минь болж
Сэтгэлийг минь сэргээж
Санаагий минь амруулсан
Зүрхний дотно нөхөд минь...

Та хоёр хамгаас урьд ирж нөхөрлөсөн тул
Хамгийг ахална
Тэнгэрт өршөөгдөж

Газарт ивээгдэг... (Дамдинсүрэн, 1976, х.69) гэж хэлээд албан тушаалд томилдог. 2009 оны эх сурвалжийн 125-р зүйлд: Чингис хаан болж, Боорчи, Зэлмэ хоёрт өгүүлрүүн:

Та хоёр намайг
Сүүдрээс өөр нөхөр үгүйд
Сүүдэр болж, сэтгэлийг минь амуулав
(амгалан болгов), та

Сэтгэлд минь байтугай

Сүүлнээс өөр ташуур үгүйд

Сүүл болж, зүрхийг минь амуулав, та

Цээжин дотор минь байтугай (Бира, Цэрэнсодном, Цэдэв, 2009, х.57) хэмээсэн байдаг. 126-р зүйлд “Чингис хааныг хаан болгосон Хэрэйдийн Тоорил хаанд Тахай, Сүхэхэй хоёрыг илгээвэл, Тоорил хаан үгүүлрүүн: Тэмүжин хөвүүний минь хан болгосон нь маш зөв. Монголчууд хангүй байж яаж болно гээд

Энэ шийдвэрээ эвдэхгүй

Эв зангаа таслахгүй

Эх захаа алдахгүй

Эгнэгт журамтай бай...” (Дамдинсүрэн, 1976, х.70) гэж хэлдэг. Мөн “Татаарыг сөнөөсөн ба Ван хантай эвдэрсэн нь” хэмээх тавдугаар бүлэг буюу 149 зүйлд “Эзэн хаан зургаан сайдаа магтан дуусахад, Боорчи эзнээ магтан дуулсан нь:

Есүхэй баатар эцэгтэй

Есөн өрлөг түшмэлтэй

Ер бүгдийг эрхэндээ оруулсан

Ертөнцийн эзэн Чингис хаан минь

Худалч хүний үгэнд

Бүү орёе

Харцага шонхор мэт

Харайлан дүүлэн явъя

Халуун амиа бүү хайрла

Ангир шувуу мэт

Амраг үрээ бүү хөнөөе

Алалцах дайсанд

Амиа бүү хайрлая

Элгэн садан дотроо

Эв найрамдлыг бүү алдъя

Эзэрхэх дайсантай тулахад

Энэ биеэ бүү хайрлая” (Дамдинсүрэн, 1976, х.135-136) гэж дуулсан магтан дуулж, ерөөсөн байдаг. Долдугаар бүлгийн 187-р зүйлд: Чингис хаан зарлиг болруун “Бадай, Хишилийг хоёрын тусынх нь тул Ван ханы алтан тэрэм бүрнээр, алтан хөнөг, аяга сав, асарч байсан ард сэлт Онхожид (овог) хэрэйдийг хэшигтэн нь болтугай хэмээж хорчлуулж (нум сум агсуулж), идээ шүүс бариулж, ургийн урагт хүртэл дархлан жаргагтун,

Мөнх тэнгэрт ивээгдэж, Хэрэйд иргэнийг доройтуулж, өндөр суудалд хүрэв ээ. Мөнөө хойно ургийн урагт минь өндөр суудалд сууж, энэ мэт тус хүргэгсдийг улам улам ухтугай” (Бира, Цэрэнсодном, Цэдэв, 2009, х.109-110) хэмээн зарлиг болгов” гэх мэт зарлиг үгэн дотор ерөөл давхар хэлэгдэж байна. “Монголын нууц товчоо”-ны долдугаар бүлэгт буюу “Ван хан сөнөсөн нь” бүлэг буюу 187 зүйлд “Чингис хаан, Ван ханы суудаг алтан асар, хэрэглэдэг алтан завъяа аяга ба асарч явсан ард сэлт, вангийн хажууд бараа боловч хэрэйд цөмийг Бадай, Хишилиг хоёрт олгож,

Хувьдаа зарцалж
Хундагаа бариулж
Хоромсогоо зүүлгэж
Ургийн урагт хүртэл

Удтал жаргатугай, та хоёр” (Дамдинсүрэн, 1976, х.100) гэж ерөөдөг. Наймдугаар бүлгийн 201-р зүйлд: Жамухын өчилд:

Хэвтвээс
Үхдэл яс минь
Өндөр этүгэнд (газар)
Үүрд мөнхжиж
Ургийн урагт чинь хүртэл

Ивээж өгье хэмээж

Ерөөл болгоё, би” (Бира, Цэрэнсодном, Цэдэв, 2009, х.134) гэж бий. Уг шүлэгт ерөөл болгоё гэж хэлж буйгаараа ерөөлийг бие биедээ хэлж, ерөөж байсныг өгүүлнэ. Мөн 234-р зүйлд:

“Хог идэж

Хомоол түлж явтугай” (Бира, Цэрэнсодном, Цэдэв, 2009, х.184), 255-р зүйлд:

“Иргэдийн инээдэм

Амьтны ханиадам бүү бологтун” (Бира, Цэрэнсодном, Цэдэв, 2009, х.185), 280-р зүйлд:

“Охор уяа дутуулбаас

Оргилоор хагас алдалтан болтугай
Халбаган хигээс дутуулбаас

Хамар хагас алдартан болтугай” гэх мэт бэлгэ дэмбэрлийн үгийн шинжтэй зүйлүүд ч олон бий. Ийнхүү “Монголын нууц товчоо”-г уншихад ерөөлийн шинжтэй зүйлүүд олон байх тул ерөөл нь XIII зуунд үүсэх биш ахуй хэрэгцээг хангаж, ард түмний дунд хэрэглээнд орж байжээ. Тийм учраас бичгийн уран зохиолын гол дурсгал болох “Монголын нууц товчоо”-нд тэмдэглэгдэн үлдсэн. Дээрх хоёр эхийг харьцуулан үзвэл 2009 онд хэвлүүлсэн эхэд ерөөлийн шинжтэй зүйлүүд илүү олон байгааг дээрх эх сурвалжууд илтгэж буй.

“Жангар” туульд: Судлаач Т.Дүгэрсүрэнгийн Халимаг хэлнээс хөрвүүлсэн

“Жангар” туулийн Догшин Шар Гүргэ мангас

Дуут Улаан Шовшуур доройтуулсан бүлэгт: Араг Улаан Хонгор “Жангар бид заргатай, сайчууд та бүхэн заргы минь шүүж өгөгтүн” гэдэг. Сайчууд шүүгээд Бумбын Хонгорын зөв болов гээд, Гунахан Улаан Шовшууртаа нэр цол өгөх болж заргаа авав.

“Төр шажин хоёроо барин гарсан

Төв бумба орноо цуглуулан гарсан

Эрх Бадамын гэгээн болтугай” гэж нэр цол өгөв. Эгнэсэн олон хаадууд цугаараа ерөөв” (Дүгэрсүрэн, 2012, х.135) гэх мэт ерөөлийн зүйл бий. Мөн 1963 оны “Жангар” туульд:

Төр шажин хоёроо барин гарсан

Төвд бумбын орноо цуглуулан гарсан

Эгэмтэй хүнд дарагдаагүй

Эр хүнд дийлэгдээгүй

Эрх Бадам гэж нэр өгөв.

Энгийн олон хаадууд цугаар ерөөв

Энэ бумбын орон нэг цагийн эхэнд

Элбэг төвхнөн жаргав (Дүгэрсүрэн, 2012, х.215) гэжихүй. “Жангар тууль”-ийн Хушуун Улаан, Баатар Жилган, Алиа Шонхор гурвын бүлэгт: “Жангар ноён гурван гомдлоо тайлж, дөчин есөн хоног найрлаж суусны дараа Баатар Бадамын Улаан:

Та хэзээний аранзал зээрдийн хурдан цагт

Өөрийн биеийн бага дүүвэр цагт

Надтай байлдаан хийгээд

Амь аргалж гарсан эс билүү?

Одоо орчлонгийн хамаг хүч тогтсон

Олон сайн баатруудтайгаа

Энэ бумбын орноо эзэлж

Элдэв сайн нэрээ дэлгэрүүлж явах болтугай...” (Дүгэрсүрэн, 2012, х.46), (Дүгэрсүрэн, 1963, х.111) гэж ерөөгөөд гэртээ харихаар морддог.

Ард нь шарын зургаан мянган

Арван хоёр баатар

Дүүвэр арзын суурь болоод

Дүүрэн жаргаад

Бурхны шажин нь нар мэт мандаад

Ертөнцийн төр нь хад мэт батжаад суув

(Дүгэрсүрэн, 1963, х.111) гэх ерөөлөөр төгсдөг.

Явсан үйлээ гүйцээж

Атан жолоо зөв эргүүлж

Алдарт ноён Жангарын

Хаш мөнгөн үүдэнд

Хариу ирж буух болооч гэж

Бадмын сайхан ерөөл тавив (Дүгэрсүрэн, 1963, х.149)

... Хай минь алтан жолоогоо зөв эргүүлж

Ар Бумбын орондоо мэнд ир” гээд

Улмын агсаг улаанаа унаад

Зөв эргэж бадмын сайхан ерөөлөө тавиад харив (Дүгэрсүрэн, 1963, х.153) хэмээжээ. Алдаршсан Эрх туг хааны хөвгүүн Орчлонгийн

3 Тухайн хүний хөрөнгийн хагасыг албан татварт авч торгохыг битүү ёстоор хэлсэн үг

сайхан Миньяаны Алдарт Богд Жангарын зарцад яваад хүчтэй Хүрмэн хааныг амьдаар хэл барьж ирсэн бүлэгт:

Найман хөлтэй

Нажир мөнгөн ширээн дээр суулгаж

Бурхны нь шажин наран мэт мандаж

Ертөнцийн төр хад мэт багжиж

Урьдахаасаа их жаргалтай болж

Эмнэг гүүдийн сүүн

Элбэг арзын суурь болоод

Жаргал цэнгэл хийгээд суув... (Дүгэрсүрэн, 2012, х.313) гэж гэрийг нь ерөөж төгсдөг. Догшин хар Гүргүүгийн бүлэгт:

Тал дунд нь

Талбайн цагаан хурал нь буурилсан

Тансаг Жангарын өлзийд

Таван сая шавь нар

Танай манайгүй тэгш жаргаж байдаг... (Дүгэрсүрэн, 1963, х.160) гэж ерөөлийн зүйлээр эхэлдэг. “Эрхэн арван наймтайдаа дөрвөн хааны нэгэн догшин Цагаан Зул хааны Гэрэнзэл гэдэг хүүхнийг Хонгор залсан” бүлэгт: Эзэн ноён Жангар

Гучин хоёр баатартайгаа залраад ирэв

Эмнэг гүүдийн сүү нь

Элбэг газрын суурь болоод

Долоон долоо

Дөчин ес хоногт

Найр наадам болов

Найрын сүүлд Богд Жангар нь

Бадмын сайхан ерөөлөө тавиад морилов (Дүгэрсүрэн, 2012, х.347) гэх мэт ерөөлүүд уг эхэд олонтаа гардаг. Ерөөл нь ирээдүйн сайн сайхныг хүсэн ерөөж төгсдөг бол тууль нь өнөө цагт сайн сайхан болж, амар жимэр амьдарч байгааг ерөөж төгсдөг.

“Хөх судар” романд: В.Инжаннашийн “Хөх судар” түүхэн романд Тэмүжиний мэндэлсэн тухай сонин сайхан дурдлага бий. “...Өлгий дээр тэмдэггүй цагаан хонины хурганы арьсаар тулам хийж, дотор өмнө газрын есөн тарианы үрийг дүүргэж дэвсээд, есөн өнгийн хив торгоор гархийг бүрхэж, гурван хоногт өврөөс гаргаж, есөн булгийн есөн зүйлийн усаар дахин ухааж, есөн өнгийн гүүний сүүгээр сүрчиж, өлгийд оруулахуйяа Жарчигудай есөн өнгийн унд, тос, тараг, зөөхийгөөр өлгийг мялааж, ийн хэмээн бэлгэлрүүн: Зээ...

Тэгш сайхан өлгийд хэвтэснээр

Тэнгэрийн үрст тэмцэл үл халдтугай

Бургасан модны өлгийд хэвтэснээр

Богдын үрст буртаг үл болтугай

Хас сайхан өлгийд хэвтэснээрхан хөвгүүн чи

Хамгийг эзлэгч хаан сууж олныг амуултугай

Дээд хөндий өлгийд хэвтэснээр дэлгэрэгч

Богд чи

Дэлхийг эзлэгч эзэн болж нийтийг жаргуултугай...” (Инжаннаши, 2009, х.99) гэж гурав, есийн тооны бэлгэдлээр ариулж, өлгий бэлдэж, их эзнийг ерөөдөг хэсэг бий. Мөн дэд бүлэгт хуримын ерөөлийг Дай Сэцэн, Мэнгэлиг хоёр харилцан хэлэлцдэг. “Дай Сэцэн “Гол мэт хүүхнийг авах тул голомтыг минь тахиж хэрэгтэй, гар мэт охиныг минь авах тул галыг минь тахиж хэрэгтэй” хэмээн эл зүйлийн ёслолыг бүридхэлгэн, есөн зүйлийн хуур цуур, шаван хөгжмөөр гучин хоёр ханат өргөө, наян нэгэн өрх гэр инжтэй буулган өгөв. Тэр үед Хонгирадын сэцэд ухаантан олон тул Тайцзуг буулгахад бас арван хоёр ханат их магнаг өргөө барьж, охиноо богтлохуйд хүргэж ирээд Тайцзугийн түшмэдийн ухааныг тэнссүгэй хэмээн “Манай магнаг гэрийг бэлгэ түгсээр магтаж, тосоор босгыг мялааж хэрэгтэй” хэмээн хэлсэнд Мэнгэлиг гэхэлзэн гарч, тосоор мялаан сацал өгч, өндөр дуугаар бэлгэлрүүн:

Эсгийгээр бүрхсэн гэр чинь

Эрдэмт дээд ордон болтугай

Эрдэмт ордонд суусан эзэн минь

Эрх хүчин нэмэгдэж ийн жарган атугай

Магнагаар бүрхсэн өргөө чинь

Маш дээд орон болтугай

Манжлагат хөшигт суусан манай эзэн

Магадаар дэлхий дахиныг эзэлтүгэй...”

(Инжаннаши, 2009, х.122) гэсэн байхад, “Буурал Луут хөшигт есөн бүч уяж, олны өмнө эрдмээ илтгэн, сүргийн дотроос цолгорон гарч, өндөр эгшигт дуугаар бэлгэлрүүн:

Магнаг луугийн химэрлэг хөшгөө татаад

Манжлага бүчнүүдийг сайтар зангидвай

Маш сайн өдөр цагт тайлснаар

Магад сайхан жаргалан

Манай хоёр урагт болтугай...” (Инжаннаши, 2009, х.123) хэмээн хэлж, хөшгийн бүчийг өөдөлж, цөм зангидвай. Мэнгэлиг зогсож, мөн алгуур аажмаар өндөр эгшиглэн бэлгэлрүүн:

Арз хорз уурагаар мялаасанд

Алдар нэр нь арван зүгт дуурьстугай

Ач үр нь сайтар дэлгэрч

Албат харцас манд үүрд хамгаалал болтугай...

(Инжаннаши, 2009, х.123) хэмээгээд есөн бүчийг эхлэн тайлахуйд нэг нэгээр бэлгэлэн өгүүллүүн:

Хаад ихэст хамт зэргэцтүгэй

Харцас иргэнд өргөгдөн хүндлэгдтүгэй

Харь холд гэгсэн хүсэгдтүгэй

Хамаг бүгдэд хаан суутугай

Есөн хүсэл ийнхүү гүйцтүгэй... (Инжаннаши, 2009, х.123) хэмээгээд цөм өөдлөн тайлан барьсан хойно, Буурал давшиж доороос дээш уяж бэлгэлэн өгүүллүүн:

Харцас иргэнээ тэжээ
Харъяат зардасаа хөгжөөн хүмүүжүүл
Хамаг боолчуудаа адилаар асран
Хэрэгт албатаа хичээн тэжээ
Хэвчүүрт түшмэдээ хэмжээлэн хэрэглэ
Хэлхээт сайдын үгийг ав
Төрсөн үрсээ сайнаар сургалтай
Түвэгдсэн хатандаа өлзийт бололтой
Түмлэвч эхдээн хариулалтай... (Инжаннаши,
2009, х.123, 124) хэмээн нэг бадаг хэлбээс, нэгэн
бүчийг уясаар цөм зангидвай. Мэнгэлиг
Сүмбэр уул мэт жавхлан цогцолтугай
Сүн далай мэт хэшиг арвидтугай
Сүмэн өвс мэт эчнээ анхилтугай
Наран, саран мэт гэрэл дүүргэтүгэй
Навч, цэцэг мэт үрс дэлгэртүгэй
Нарс, майлаас мэт насан уртадтугай...
(Инжаннаши, 2009, х.124) хэмээн тайлан барсанд,
Хүйсний Буурал, Хонхотны Мэнгэлигийн есөн
мэндээр бэлгэлэн өгүүлснийг үзээд, бас дахин
зангидсугай хэмээв. Арван наймдугаар бүлэгт
“... Хасар ба Зэлмийн хоёулыг харжийн хэмээн
захируун:

Тэнгэр эцэг Тэмүжин хөвгүүн надад нэгэнт
хүртээвээс

Тэмдэгт миний төгс рашаан болсон нь тулд

Түүгээр миний гараар уулгаваас, магад
тогтоод

Түүний биед амтат рашаа шингэх болтугай...
хэмээгээд өөрийн мутраар, тэр

нэгэн алтан цогцийг барьж, Хасар ба Зэлмэ
хоёулд хуваан уулгасанд...”, “... Тайцзу хоёр гараан
Хасар, Зэлмэ хоёулын мөрд тавьжийн хэмээн
захируун:

Тэнгэрийн рашааныг тэгшлэн хүртэж чадсан
та хоёул

Төгсбүрдэх үр ач нар чинь тэнцэшгүй мандаж

Тэмүжин миний хүүхэд ач нар лугаа тэн сацуу
явж

Түүтгэрэлгүй гурван мянган онд долоонтоо
дэлгэртүгэй! хэмээн ерөөн

соёрхвой... “Уг сударт хэлсэн нь: Тайцзугийн
тэнгэрийн рашааныг тэнгэрлэг эзний мутраар
уулган, алтан амаар ийнхүү ерөөснөөр эдүгээ Хавт
Хасарын үрс, Зүүн хорчин арван хошуу, баруун
Хөх нуур, Алагшаатай нийт дөчин таван хошуу,
жич Зэлмийн үрс гурван харчин, зүүн Түмэдтэй
нийт дөрвөн хошуу дэлгэрч, Богдын үрс нэг зуун
далан хошуу лугаа тэн чацуу ураг барьж явах нь
энэ тэнгэрийн рашааныг тэнгэрлэгийн гараас
хүртэж амсаад, тэмдэгтэйээ энэ үнэн үгс бүтсэн үг
зарлиг бэлгэ ерөөлөөс болов хэмээжүхүй. Тийнхүү
аргагүй уг ёсоор бичив” (Инжаннаши, 2009, х.449)
гэсэн нь ерөөл, бэлгийн үгийг ихэд бэлгэшээдэг

ард түмэн гэдгийг харуулжээ. В.Инжинашийн
“Хөх судар” түүхэн зохиол нь тэр чигээрээ
бэлгэдлийг агуулсан, тэр тусмаа ерөөл, бэлгийн
үгийг ийнхүү түлхүү хэрэглэж, бичиж оруулж
буй нь XIX зуунд харьцангуй өргөн тархаж,
ард түмний ёс заншил, зан үйлийн хэрэгцээнд
орж, мөн бие даасан төлөөлөгчтэй болж буй тэр
хэрээр ерөөл нь хөгжиж байсныг илтгэдэг. Энэ
түүхэн цаг үед ерөөлийг бичгийн хэлэнд буулгаж,
бичиж тэмдэглэж, эмхэтгэж байсан мэдээ баримт,
мэдээ сэлтүүд байдаг. Мөн бурхны шашны нөлөө
ерөөлийн төрөл зүйлд аль хэдийн тогтож, гар
бичмэл, судар хэлбэрээр бичигдэн үлдэж байжээ.

“Үг” зохиолд: Хуульч Сандаг хэмээн
алдаршсан XIX зууны нэрт зохиолчийн бүтээлд
ажиглалт хийж, түүний бүтээлд ерөөлийн шинжүүд
бий гэж үзлээ. “ҮГ” зохиолын гол төлөөлөгч Хуульч
Сандагийн бүтээлд хэд хэдэн ерөөлийн шинж бий.
“Үг” зохиол нь XIX зуунд монголын уран зохиолд
гарсан цоо шинэ төрөл юм. Тухайлбал: “Тэжээсэн
нохойны хэлсэн нь” хэмээх уг зохиол нь эхлэлтэй,
өрнөлтэй, ерөөж төгсгөсөн байдал зэргээс харахад
ерөөлийн шинжийг агуулжээ.

Нүүхэд явган дагадаг

Нүцгэн яс хэмлэдэг

Нүнжиггүй хоол иддэг

Гэвч яахав

Эртний ерөөлөөр учирсан

Эзэнтэйгээ

Эндэлгүй наслаад

Энх амар жаргая (Чимид, 1981, х.22) гэжээ.

“Хурган хуцны хэлсэн нь”:

Үнэрхэхийн сэтгэлгүй

Эзнээсээ холдолгүй

Эвгүй газар эндэлгүй

Энх талыг бүтээж

Элбэг усыг ширгээж

Үүрт өсөн жаргая (Чимид, 1981, х.28) гэж
хурган хуц хэлж байхад, “Ухны хэлсэн нь” зохиолд

Энгүй олон болж

Үй түмэн болон жаргая

Үр шим алдалгүй

Өнөд өсөн жаргая (Чимид, 1981, х.28) гэжээ.

Ан шувуу гэгч

Ертөнцийн ёс гэнэ /жам юм биз/

Адгуусны төрлөөс гэтлээд

Амар төрлийг олох минь болтугай” (Чимид,
1981, х.26) гэх мэт хуульч Сандагийн зохиолууд
нь өнөөдрийн зовлонгоос ирээдүйн сайн сайханд
тэмүүлж ерөөн бэлгэдсэн утгаар төгсжээ. Мөн
“Өөрийн бие өтлөөд ноёноо магтаж хэлсэн нь”
зохиолд:

Дуртмал шинийн сар мэт

Тунгалаг дээд Богдыгоо

Толыг зүрхэндээ шүтмээ нь
Тонилохын мөрийг олъё хэмээн магтаад...,
төгсгөлд нь

Эрдэнийн дээд лам ба
Эрхт эздийн сүлдээр
Эдүй даяар чингэж ялангуяа
Эцсийн амрыг олоод

Эвдрэл үгүй жаргая (Сүглэгмаа, 2006, х.73-75) гэх мэт Хуульч Сандаг нь зохиол бүрийнхээ төгсгөлд амар тайван аж төрөх, сайн сайхан байх, жаргалтай байх зэргээр ерөөж төгсгөсөн нь нийтлэг байна. Үүнийг тухайн үеийн ерөөлийн хөгжил нь амаар дамжин түгэх хийгээд бичгийн уран зохиол болоод “Үг” хэмээх шинэ төрөл зүйлд ч бас нөлөөлж байжээ гэж хэлж болно.

Эдгээрээс үзэхэд XIII зууны үеэс зохиогдсон аман болоод сонгодог бичгийн гол эх сурвалжуудаас жишээ татахад ерөөл нь үлэмжхэн ч гэсэн маш тод бичигдэж үлджээ. Монголын ард түмэн үгийн цэцнээр ярилцаж, үйлийн бэлгэдэл агуулж ирсэн угийн бэлгэ авьяастай учир тэр хэрээрээ аман зохиол нь бичгийн уран зохиолд нөлөөлж, бичгийн зохиол нь аман зохиолынхоо дурсгалыг тээж шингээж ирсэн гэдгийг эдгээр баримтуудаас үзэж болох юм. Ерөөл нь дан ганц амаар уламжлагдсангүй, бичгийн уран зохиолд монголын тухайн үеийн ард түмний аж байдал, амьдрал ахуй, ёс заншил, зан үйлийг тээж ирэхдээ соёлын олон үнэт зүйлийг агуулж иржээ. XIII зууны үед ерөөл нь хэрэгцээ шаардлага хангаж, ашиглагдаж хэрэглэгдэж байсан ба “Хөх судар” хүртэлх түүхэн урт замыг туулахдаа ардын ёс заншил, зан үйл зэрэг нь нэвт тусаж, тусгай бие

даасан төрөл зүйл болтол хөгжсөн байна.

Ашигласан материал

- Аръяасүрэн, Ч., Нямбуу, Х. (1992). *Монгол ёс заншлын их тайлбар толь, I*. Улаанбаатар.
- Монголын зохиолчдын эвлэл. (1999). *Монголын уран зохиолын дээжис: Гэсэр, 59 боть*. Улаанбаатар.
- Балдаев, С. (1961). *Бурятские народные песни, Том, I*. Улан-Удэ.
- Бира, Ш., Цэрэнсодном, Д., Цэдэв, Д., бусад. (2009). *Монголын нууц товчоо*. Улаанбаатар.
- Гаадамба, Ш., Сампилдэндэв, Х. (1988). *Монгол ардын аман зохиол*. Улаанбаатар.
- Дамдинсүрэн, Ц. (1976). *Монголын нууц товчоо*. Улаанбаатар.
- Дүгэрсүрэн, Т. (1963). *Жангар тууль*. Улаанбаатар.
- Дүгэрсүрэн, Т. (2012). *Жангар тууль, дэд боть*. Улаанбаатар.
- Дүгэрсүрэн, Т. (2012). *Жангар тууль, тэргүүн боть*. Улаанбаатар.
- Инжаннаши, В. (2009). *Хөх судар, тэргүүн дэвтэр*. Улаанбаатар.
- Михайлов, Г. (1971). *Литературное наследство Монголов*. Москва.
- Сүглэгмаа, Х. (2006). *Халхын хуульч хэмээх цэцэн Сандаг*. Улаанбаатар.
- Чимид, Ө. (1981). *Хуульч Сандагийн зохиолуудын түүвэр*. Улаанбаатар.
- Чимид, Ө. (Эмх). (1981). *Хуульч Сандагийн зохиолын түүвэр*. Улаанбаатар.

There are blessing ethnics traditionaly come from oral speech and writing literature

B.Urangoo

University of Arts and Culture, Theater and Art School, Department of Art Studies and Literature

Abstract

The paper intends to discuss how one of the most distinctive forms of worship in Mongolian Folklore has been written, expressed and described in the main sources of ancient Mongolian literature sources such as the “three peaks” of Mongolian literature, *The Secret History of the Mongols*, *Word*, *Geser* and *Jangar* and finally, to identify the symbolic words and their meanings. The study mainly focuses on the analysis of the symbols of words that have symbolic meanings in these three novels. More specifically, it has identified and investigated the symbolic meanings of words and explained them with clear illustrations and examples. It has been concluded that Mongolian oral literature has greatly influenced on the written literature which contains a rich history of oral folklore. Otherwise, praises or eulogy has not only been delivered orally, but also kept in the written literature that has also been a reflection of the society of the given time, its level of political, economic and social development as well as leading intellectual trends.

Key words

The Secret History of the Mongols, Jangar, Geser, Word Literature.